



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар

1/247

Мандалговь

“Шувуутай-Оргил” ХХК-тай гэрээ байгуулах
тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 33 дугаар зүйл 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Терроризмтай тэмцэх зөвлөлийн аймаг дахь салбар зөвлөлд тоног төхөөрөмж” нийлүүлэх ажилд ирүүлсэн үнийн саналаар “Шувуутай-Оргил” ХХК-тай 11,215,000 (арван нэгэн сая хоёр зуун арван таван мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан техникийн үзүүлэлтийн дагуу “Терроризмтай тэмцэх зөвлөлийн аймаг дахь салбар зөвлөлд тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Шувуутай-Оргил” ХХК-ний гүйцэтгэх захирал (Л.Алтанжаргал)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4862111-4